

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.7	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



МАЛ ЭМНЭЛГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.28 № 06/356
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг хүрээлэнгийн захирал Б.Батцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн бараа материалыг шууд дансаар бүртгэхгүй байх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс 2019 оны 2 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ийн аудитор Н.Уранчимэг, аудиторын туслах Д.Должидмаа нар хариуцан хэрэгжүүлэв.

Мал эмнэлгийн хүрээлэн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 2/39 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Мал эмнэлгийн хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Мал эмнэлгийн хүрээлэн нь мал амьтны өвчнийг оношлох, эмчлэх, тэдгээрээс сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангах арга, технологийг боловсруулан Монгол улсын хүн амын эрүүл, таатай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Мал эмнэлгийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал эмнэлгийн шинжлэх ухааны судалгааг хөгжүүлэн, мал амьтан, нийгмийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг сахин хамгаалах, шинэ арга технологи боловсруулах
- Мал эмнэлгийн салбарт шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх
- Мал эмнэлгийн магистрант, докторант зэрэг нарийн мэргэжлийн мэргэшсэн судлаачид бэлтгэх, судалгааны орчинг бүрдүүлэх, мал эмнэлгийн салбарын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх,
- Малчдад мал эмнэлгийн шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх чиглэлээр мэдлэг олгох
- Судалгаа шинжилгээний үр дүнг нийтийн хүртээл болгох, хэвлэн нийтлүүлэх, шинэ бүтээл, технологи, мэдлэгийг патентжуулах, эрхийн хамгаалалт хийх, технологи

дамжуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх эдгээр ажлуудыг үндсэн чиг үүрэг болгон ажиллаж байна.

Мал эмнэлгийн хүрээлэнгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Мал эмнэлгийн хүрээлэнгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шинжлэх ухаан технологийн тухай
- Инновацийн тухай хууль

Тайлант хугацаанд тус байгууллагын мөрдөж байгаа хууль эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлан мөрдүүлж байгаа уг бодлого нь тухайн байгууллагын онцлог буюу хэд хэдэн тайлангийн хугацаанд хамрагдах эрдэм шинжилгээний ажлын зардал болон түүнтэй холбоотой санхүүжилтийн орлогыг хэрхэн яаж тусгах талаар тодорхой тусгаагүй байна.

Мал эмнэлгийн хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мал эмнэлгийн хүрээлэн санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн “Acoulous” програмыг ашигладаг байна.

Мал эмнэлгийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад тус байгууллагын дотоод хяналтыг

Эрдэмтэн нарийн бичгийн дарга, лабораторийн эрхлэгч нар хариуцан хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд тус байгууллагын үйлдвэрчний хороотой хамтран хоёр удаа хяналт хийсэн тайлан ирүүлсэн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Мал эмнэлгийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын 1 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгосон ба гүйцэтгэлийн үе шатанд санхүүжилтийн орлого нэмэгдсэн тул нийт орлогыг сонгох нь зүйтэй гэж үзлээ.

Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,725,602.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 17,256.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг шинээр илрүүлж аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөг/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	3,250.0	
2	Албан шаардлага өгсөн	1	5,242.2	
	Дүн	2	8,492.2	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулав. Төслийн ажилчдын цалингаас нийгмийн даатгалын шимтгэл 3,951.9 мянган төгрөгийг суутгасан боловч нийгмийн даатгалын санд төвлөрүүлээгүй, үндсэн ажлаас гадуур төслийн цалин авдаг ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг дутуу тооцсоны зөрүү 1,290.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудлын хувьд эрдэм шинжилгээний ажлыг 2016 оноос эхэлсэн, үргэлжлэн хэрэгжих төслийн санхүүжилтийн тайлант жилийн зардлыг урьдчилж төлсөн зардал дансанд хуримтлуулан бүртгэж тайлагнасан байна. Шинжлэх ухаан технологийн сангаас ирсэн албан тоотод Эрдэм шинжилгээний төслийн санхүүжилтийг урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэх тухай шийдвэрийг үндэслэн бүртгэж байгаа нь орлого, зарлагын уялдаатай, нягтлан бодох бүртгэлийн жинхэнэ хэрэгжилтийн зарчимтай нийцэхгүй байгаа нь анхаарал татсан асуудал болж байна.

Дараагийн аудитаар

1. Эрдэм шинжилгээний зардлыг нарийвчлан авч үзэх
2. Үндсэн хөрөнгийн үнэлгээний дансны бичилтийг зөв хийсэн боловч барилга байгууламжийн дахин үнэлгээний нэмэгдсэн дүнг дахин нягтлах шаардлагатай байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Мал эмнэлгийн хүрээлэнгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой суурь судалгааны төсөл 7, шинжлэх ухааны төсөл 8, инновацийн төсөл 7 нийт 22 төсөл, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,586,913.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,574,638.7 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байна. Тайлант жилд нийт зардлыг 185.7 мянган төгрөгөөр хэмнэсэн ба эдийн засгийн ангиллаар авч үзэхэд төсвийн зардал хэтрээгүй байна.

Үндсэн үйл ажиллагаанаас олох орлогын төлөвлөгөө 20,000.0 мянган төгрөг батлагдсанаас 6,708.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энэ нь дээд шатны төсвийн захирагчаас орлогын төлөвлөгөөг тус байгууллагын үйл ажиллагааны орлого олох эх үүсвэртэй уялдуулж батлаагүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Мал эмнэлгийн хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны цахим хуудсанд төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 20 мэдээлэл оруулахаас 18 мэдээлэл оруулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж хариуг 2018 оны 10 дугаар сарын 23-нд 2/402 тоот албан тоотоор хүргүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мал эмнэлгийн хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Эргэлтийн хөрөнгийн талаар

1. Илрүүлэлт:

Тайлант онд 1,550.0 мянган төгрөгийн шатахуун, 1,700.0 мянган төгрөгийн эргэлтийн сүргийн мал худалдан авч материалын дансанд бүртгэлгүйгээр шууд зардалд бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ын 4.20-д “Төсөвт байгууллага нь бараа материалыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа байнгын системийн аргыг ашиглана” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

2. Эрсдэлүүд:

Санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдэл хангагдахгүй байх

3. Зөвлөмж: Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж ажиллах

4. Төсвийн захирагчийн хариу: Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 7 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>762,378,509.50</u>	<u>1,186,320,284.48</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,205,290.00	2,890.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,200,790.00	790.00
31110	Төгрөг	1,200,790.00	790.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,500.00	2,100.00
3121	Төгрөг	4,500.00	2,100.00
31213	Арилжааны банк дахь харилцах	4,500.00	2,100.00
33	АВЛАГА	90,308,021.18	24,865,347.91
33300	Татаас, санхүүжилтийн авлага	90,308,021.18	21,376,625.91
335	Бусад авлага		3,488,722.00
3351	Байгууллагаас авах авлага		3,488,722.00
34	УРЬДЧИЛГАА	356,471,113.31	863,002,707.68
34600	Урьдчилж гарсан зардал	356,471,113.31	863,002,707.68
35	БАРАА МАТЕРИАЛ	314,394,085.01	298,449,338.89
351	Түүхий эд материал	242,405,548.69	202,054,000.67
35110	Тусгай зориулалттай материал	242,405,548.69	202,054,000.67
354	Хангамжийн материал	57,708,536.32	82,115,338.22
35420	Аж ахуйн материал	54,313,866.32	72,820,668.22
35430	Сэлбэг хэрэгсэл		5,900,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,394,670.00	3,394,670.00
35600	Мал амьтад	14,280,000.00	14,280,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,176,585,628.23</u>	<u>1,741,968,488.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,176,585,628.23	1,741,968,488.03
392	Биет хөрөнгө	1,176,585,628.23	1,547,470,184.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	548,120,200.00	537,731,050.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-489,886,985.29	-15,073,158.93
39203	Авто-тээврийн хэрэгсэл	83,814,080.00	83,814,080.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-83,814,080.00	-83,814,080.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,551,095,395.62	3,299,231,304.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,698,807,132.37	-2,506,528,349.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	585,244,935.50	522,142,268.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-319,180,785.23	-290,032,931.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	747,400.00	747,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-747,400.00	-747,400.00
393	Биет бус хөрөнгө		194,498,304.00
39301	Програм хангамж	1,000,000.00	1,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,000,000.00	-1,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		194,498,304.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,938,964,137.73</u>	<u>2,928,288,772.51</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,989,432.73</u>	<u>36,396,271.51</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,989,432.73	36,396,271.51

Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

413	Өглөг	6,989,432.73	36,396,271.51
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	6,989,432.73	35,958,271.51
4136	Бусад өглөг		438,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		438,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,931,974,705.00	2,891,892,501.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,931,974,705.00	2,891,892,501.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,265,416,520.05	3,459,914,824.05
51101	Өмч: - төрийн	3,265,416,520.05	3,459,914,824.05
512	Хуримтлагдсан үр дүн	-1,397,287,695.50	-1,106,131,883.62
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,397,287,695.50	-1,397,287,695.50
51220	Тайлант үеийн үр дүн		291,155,811.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	63,845,880.45	538,109,560.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,938,964,137.73	2,928,288,772.51

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	961,742,186.00	1,725,601,668.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,865,200.00	6,708,847.43
120	Нийтлэг татварын бус орлого	1,865,200.00	6,708,847.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,865,200.00	6,708,847.43
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,865,200.00	6,708,847.43
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	959,876,986.00	1,718,892,820.84
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	535,890,800.00	1,566,913,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	535,890,800.00	1,566,913,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	423,986,186.00	151,979,520.84
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	382,158,686.00	111,479,520.84
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,827,500.00	40,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	867,091,964.25	1,434,445,856.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	867,091,964.25	1,434,445,856.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	867,091,964.25	1,434,260,082.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,494,005.06	920,826,577.94
210101	Үндсэн цалин	454,494,005.06	920,826,577.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,582,200.00	111,541,444.86
210201	Тэтгэврийн даатгал	43,582,200.00	111,541,444.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,258,740.41	67,670,102.00
210301	Гэрэл, цахилгаан	14,187,843.41	35,913,246.00
210302	Түлш, халаалт	11,104,607.00	21,408,936.00
210303	Цэвэр, бохир ус	1,966,290.00	10,347,920.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,412,825.00	2,309,960.86
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	1,550,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	570,575.00	605,960.86
210401	Бичиг хэргийн материал		154,000.00
210404	Ном, хэвлэл	1,242,250.00	
2105	Нормативт зардал	60,000.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,000.00	
2107	Томилолт, зочны зардал	54,264,608.00	39,841,560.00
210702	Дотоод албан томилолт	54,264,608.00	39,841,560.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,744,361.98	135,950,255.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,744,361.98	132,716,255.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		634,000.00

Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	198,275,223.80	156,120,181.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,709,134.17	1,630,821.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		5,871,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	191,566,089.63	148,618,060.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		185,773.63
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		185,773.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		185,773.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	94,650,221.75	291,155,811.88
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	94,650,221.75	291,155,811.88

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,984,150,689.89	1,820,457,244.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,221,165.38	11,526,002.43
120	Нийтлэг татварын бус орлого	35,221,165.38	11,526,002.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,221,165.38	11,526,002.43
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,110,359.00	6,708,847.43
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,110,806.38	4,817,155.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,948,929,524.49	1,808,931,242.02
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,326,930,300.00	1,566,913,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,326,930,300.00	1,566,913,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	611,789,900.49	242,017,942.02
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	582,089,900.49	201,517,942.02
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,700,000.00	40,500,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,209,324.00	
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	10,209,324.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,881,757,199.87	1,776,420,708.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,881,757,199.39	1,776,420,708.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,761,824,343.68	1,751,639,186.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	874,466,776.00	904,381,578.07
210101	Үндсэн цалин	874,466,776.00	904,381,578.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,769,600.00	102,506,327.95
210201	Тэтгэврийн даатгал	57,762,472.83	102,506,327.95
210202	Тэтгэмжийн даатгал	6,601,425.45	
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,251,781.82	
210204	Ажилгүйдлийн даатгал	1,650,356.26	
210205	Эрүүл мэндийн даатгал	16,503,563.64	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,639,697.99	67,670,102.00
210301	Гэрэл, цахилгаан	34,714,131.99	35,913,246.00
210302	Түлш, халаалт	20,299,300.00	21,408,936.00
210303	Цэвэр, бохир ус	4,626,266.00	10,347,920.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,611,260.00	3,266,960.86
210401	Бичиг хэрэг	1,270,210.00	1,111,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,707,942.83	1,550,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	803,857.17	605,960.86
210404	Ном, хэвлэл	3,829,250.00	
2105	Нормативт зардал	60,000.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,000.00	

Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,274,600.00	
210604	Урсгал засвар	1,274,600.00	
2107	Томилолт, зочны зардал	78,976,788.00	39,841,560.00
210702	Дотоод албан томилолт	78,976,788.00	39,841,560.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	615,000,315.31	623,041,104.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	613,010,156.31	620,245,104.65
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		196,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		100,000.00
210807	Газрын төлбөр	990,159.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,025,306.38	10,931,553.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,110,806.38	2,872,253.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,914,500.00	8,059,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	119,932,856.19	24,781,521.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,400,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,400,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	93,532,856.19	24,781,521.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	93,532,856.19	24,781,521.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>102,393,490.00</u>	<u>44,036,536.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	102,395,890.00	45,238,936.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	102,395,890.00	45,238,936.00
2200	Дотоод эх үүсвэрээр	102,395,890.00	45,238,936.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	102,395,890.00	45,238,936.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-102,395,890.00</u>	<u>-45,238,936.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-2,400.00	-1,202,400.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,207,690.00	1,205,290.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,205,290.00	2,890.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,265,416,520.05	63,845,880.45	-1,995,240,630.44	1,334,021,770.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,265,416,520.05	63,845,880.45	-1,995,240,630.44	1,334,021,770.06
Тайлант үеийн үр дүн			597,952,934.94	597,952,934.94
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,265,416,520.05	63,845,880.45	-1,397,287,695.50	1,931,974,705.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,265,416,520.05	63,845,880.45	-1,397,287,695.50	1,931,974,705.00
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн		474,263,680.12		474,263,680.12
Тайлант үеийн үр дүн	194,498,304.00		291,155,811.88	485,654,115.88
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,459,914,824.05	538,109,560.57	-1,106,131,883.62	2,891,892,501.00

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,205,290.00	-1,205,290.00	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,586,913,300.00	1,574,638,773.80	12,274,526.2	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,586,913,300.00	1,574,638,773.80	12,274,526.2	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,586,913,300.00	1,574,638,773.80	12,274,526.2	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	835,399,500.00	828,634,680.57	6,764,819.4	99.1
210101	Үндсэн цалин	712,471,800.00	828,634,680.57	-116,162,880.6	116.3
210102	Нэмэгдэл	84,392,400.00		84,392,400.0	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,826,000.00		32,826,000.0	
210104	Урамшуулал	5,709,300.00		5,709,300.0	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,848,300.00	97,848,300.00		100
210201	Тэтгэврийн даатгал	97,848,300.00	97,848,300.00		100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,705,900.00	67,670,102.00	2,035,798.0	37
210301	Гэрэл, цахилгаан	28,910,700.00	35,913,246.00	-7,002,546.0	124.2
210302	Түлш, халаалт	28,795,200.00	21,408,936.00	7,386,264.0	74.3
210303	Цэвэр, бохир ус	12,000,000.00	10,347,920.00	1,652,080.0	86.2
2104	Хангамж, бараа материалын зардал	2,611,700.00	2,609,960.86	1,739.1	99.9
210401	Бичиг хэрэг	500,000.00	454,000.00	46,000.0	90.8
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,550,000.00	-350,000.0	129.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	816,700.00	605,960.86	210,739.1	74.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	95,000.00		95,000.0	
2107	Томилолт, зочны зардал	23,124,400.00	23,121,800.00	2,600.0	99.9
210702	Дотоод албан томилолт	23,124,400.00	23,121,800.00	2,600.0	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	558,223,500.00	554,566,530.37	3,656,969.6	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	552,319,000.00	551,770,530.37	548,469.6	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00		100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	304,500.00	196,000.00	108,500.0	64.3

Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00		100
210807	Газрын төлбөр	3,000,000.00		3,000,000.0	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		187,400.00	-187,400.0	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		187,400.00	-187,400.0	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,586,913,300.00	1,573,436,373.80	13,476,926.2	99.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,566,913,300.00	1,566,727,526.37	185,773.6	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,566,913,300.00	1,566,727,526.37	185,773.6	99.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,000,000.00	6,708,847.43	13,291,152.6	33.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	6,708,847.43	13,291,152.6	33.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,205,290.00	-1,205,290.0	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,890.00	-2,890.0	

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		219,554,495.73	-219,554,495.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ		219,554,495.73	-219,554,495.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		219,554,495.73	-219,554,495.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		75,746,897.50	-75,746,897.50
210101	Үндсэн цалин		75,746,897.50	-75,746,897.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,658,027.95	-4,658,027.95
210201	Тэтгэврийн даатгал		4,658,027.95	-4,658,027.95
2104	Хангамж, бараа материалын зардал		657,000.00	-657,000.00
210401	Бичиг хэрэг		657,000.00	-657,000.00
2107	Томилолт, зочны зардал		16,719,760.00	-16,719,760.00
210702	Дотоод албан томилолт		16,719,760.00	-16,719,760.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		113,713,510.28	-113,713,510.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		113,713,510.28	-113,713,510.28
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		8059300.00	-8,059,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		8,059,300.00	-8,059,300.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		219554495.73	-219,554,495.73
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		219,554,495.73	-219,554,495.73
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		179,054,495.73	-179,054,495.73
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		40,500,000.00	-40,500,000.00

4.7 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.25	Аудитын нэр:	“Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/45/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Мал эмнэлгийн хүрээлэн”		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Д43 төслийн цалингаас нийгмийн даатгалын шимтгэл тооцоод төлөөгүй 3,951.9 сая төгрөг, үндсэн ажлаас гадуур төслийн цалин авдаг ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээг дутуу тооцсоны зөрүү 1,290.3 мянган төгрөг	5,242.2	Албан шаардлага өгөв	Нягтлан бодогч	А.Энхсайхан
2	Тайлант онд худалдаж авсан шатахуун, хээлтэй ингийг холбогдох дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн	3,250.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	А.Энхсайхан
	Нийт дүн	8,492.2			

